



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

**Сонгинохайрхан дүүргийн 2025 оны газар зохион  
байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, 2026 оны  
газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2025 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг “Бүрэн хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Сонгинохайрхан дүүргийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
3. Сонгинохайрхан дүүргийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Ц.Баттөр)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ногоон хөгжил, газрын харилцаа, хөдөө аж ахуйн хороо (Ж.Гантогтох)-нд даалгасугай.

ДАРГА  Б.ЗОЛБОО



Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 1-дугаар сарын 17-ны өдрийн 3-дугаар тогтоолын хавсралт



ДҮҮРГИЙН 2026 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ  
НЭГ.ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР


Д/Д	Хэрэгжүүлэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Төлөвлөгөөнд тусгах үндэслэл
<b>Нэг.Хууль эрх зүйн хүрээнд хийгдэх ажил</b>				
1.	Газрын багц хуулийн төсөлд санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх, дагаж мөрдөгдөх дүрэм, журмын төсөлд санал тусгуулах;	ДГЗБА	I-IV улиралд	Үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон дэд бүтцийн болон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаатай холбогдон улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэх, газрын эдийн засгийн үр өгөөж ихээхэн нэмэгдэж байгаа зэрэг шалтгааны улмаас газрын эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, эрх зүйн шинэтгэл хийх, газрын нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх зэргээр нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Газрын тухай багц хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн.
2.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 69 дүгээр тогтоолоор Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоосонтойгоор холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах;	ДГЗБА	I-IV улиралд	Монгол Улсын Усны тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангах.
3.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг Улаанбаатар хотын эдэлбэр газар, түүнтэй холбоотой дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэх;	ДГЗБА	I-IV улиралд	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль.
4.	Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах.	ДЗДТГ	I-IV улиралд	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоол.
<b>Хоёр.Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил</b>				
5.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан	ДГЗБА	I-IV улиралд	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын газар зохион

	хэрэгжилтийг зохион байгуулах;			байгуулалтын төлөвлөгөө", Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт.
6.	Дүүргийн нутаг дэвсгэрт гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох саналыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гудамжны нэрийн саналыг боловсруулж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, нэршүүлэх;	ДГЗБА	I-IV улиралд	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.17, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол.
7.	Газар эзэмших эрх нь дуусгавар болсон, зөвшөөрөлгүй ашигласан газрыг нийтийн эзэмшлийн газар болгож, уг газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барих, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах нөхцөлийг бүрдүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоох, нэмэлт өөрчлөлт оруулах холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах;	ДЗДТГ	I-IV улиралд	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Зорилт 2.5, 9.2 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4.1 дэх заалт Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.1 дэх заалт.
8.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг сайжруулахад холбогдох газарт санал хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;	ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол, дүүргийг 2020-2024 онд хөгжүүлэх дөрвөн жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дахь заалт.
9.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, мод үржүүлгийн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох санал хүргүүлэх.	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай 58 дугаар зарлигийн хүрээнд Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2021 оны 03 дугаар зөвлөмж, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамж.
<b>Гурав.Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил</b>				
<b>Хот байгуулалтын чиглэлээр:</b>				
10.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нөхөн олговор олгохоор тусгагдсан бүтээн байгуулалтын ажлуудад газар чөлөөлөхөд дэмжлэг үзүүлэх;	ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2023 оны тогтоол.
11.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолоор батлагдсан Дүүргийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	"Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, ЗТБХБСайдын 2010 оны 418 дугаар тушаал.

12.	Авто замын түжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт газар эзэмших, ашиглах эрхийн зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг арилгах;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175 дугаар тогтоол.
13.	Дүүргийн нутаг дэвсгэрт шинээр байгуулагдсан хороодын нийгмийн хангамжийн барилга, байгууламжийн газрын байршил хэмжээг тогтоож шийдвэрлэх;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/36 дугаар тогтоол.
14.	Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд барилгын норм дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон дүүргийн Засаг даргын захирамжийг судлан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний талбайг хэсэгчилэн буюу бүхлээр нь хүчингүй болгох зэрэг холбогдох арга хэмжээг авах.	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1 "Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл (эс үйлдэхүй)-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно" дэх заалт.
<b>Газар зохион байгуулалтын чиглэлээр:</b>				
15.	Дүүргийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан газар нутгийн судалгааг гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал бэлтгэн, холбогдох шийдвэрийг гаргуулах, хянан баталгаагаар илэрсэн зөрчлийг арилгуулах;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.7 "Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" дахь заалт.
16.	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах, зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах;	ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.6 "Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" дахь заалт.
17.	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах;	ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.6 "Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг

				<p>дарга, бусад газрын төлөө байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" дахь заалт.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн "Хот тосгон бусад суурин газрын мониторингийн 300 цэгт хөрсний бохирдлын судалгааны ажлыг эцэслэн зохион байгуулах" удирдамж.</p>
18.	<p>Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, газар эзэмших, ашиглах эрхийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулах;</p>	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	<p>Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгагдсаны дагуу 1.улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарсан байршилтай давхацсан, 2.Улс, нийслэлийн төсөв, гадаад зээл, тусламжаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх байршилтай давхацсан, 3.хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүс, зурвас газартай давхацсан, 4.геодезийн солбилцол, өндөр тусгагийн тогтолцоо өөрчлөгдсөн, 5.газар зохион байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэх, 6.нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, 7.хүн ам, барилгажилтын нягтрал ихтэй бүсэд байрлах газрыг нийтийн эдэлбэр газарт авах, 8.байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэлд орсон, 9.нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн шийдвэр зэргийг үндэслэн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар ашиглалтын бүсчлэлд нийцүүлэн эзэмшил газрын хэмжээ, байршлыг өөрчлөх үйл ажиллагааг зохион байгуулах;</p>
19.		ДГЗБА	I-IV улиралд	<p>Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт.</p>
20.	<p>Газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ шинэчлэх үйл ажиллагаанд хамрагдаагүй үлдсэн газар эдлэх эрхийн үнэмлэхтэй, тухайн газраа олон жил амьдарсан боловч газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ авч байгаагүй иргэдийн газар эзэмших эрхийг хууль тогтоомжид заасан хугацаагаар холбогдох журмын дагуу шинэчлэн олгох;</p>	ДГЗБА	I-IV улиралд	<p>Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 "Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байна" дэх хэсэг.</p>
21.	<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газар эзэмшиж ашиглаж байгаа иргэн хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, хугацаа сунгах, зориулалт, талбайн хэмжээ, байршил кадастрын зургийн хэлбэр, хаяг өөрчлөх, хүсэлтийг шийдвэрлэх хурлаар хэлэлцүүлэн гарсан шийдвэрийн дагуу өөрчлөлт орсон нэгж талбарын мэдээллийг тухай бүрт баяжуулж газрын</p>	ДГЗБА	I-IV улиралд	<p>Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>



	цахим мэдээллийн санг хөтлөх;					
22.	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь хүчингүй болгох үндэслэл бүрдсэн газар эзэмшигч ашиглагчийн судалгааг гаргаж, "газар эзэмших эрх, эрхийн гэрчилгээ" хүчингүй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;	ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл		
23.	Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газар эзэмшигч ашиглагчийн гэрээг дүгнэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хууль.		
24.	Дүүргийн 24, 29, 35 дугаар хороог дахин зохион байгуулж зөрчилгүй хороо болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;	ДЗДТГ, НГЗБА	I-IV улиралд	Холбогдох хууль тогтоомжууд.		
25.	Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан дүүргийн нутаг дэвсгэрт шар усны уер, халиа дошин үүсч нөхцөл байдал хүндэрч хохирол учирч болзошгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж дүүргийн онцгой комисс, хороодтой хамтран нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах нөхөх олговор олгох, газар чөлөөлөх;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 69 дүгээр тогтоол.		
26.	Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эдэлбэрийн газар, гудамж, зам, талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан зөөврийн байгууламж бүх төрлийн объект болон нийслэл, дүүргийн захирамжаар өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газраа дүр мэдэн сунгасан хашаа, хайсыг нүүлгэн шилжүүлж газрын зөрчил арилгах.	ДГЗБА	I-IV улиралд	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд.		
<b>Дөрөв. Газар өмчлөлийн чиглэлээр хийгдэх ажил</b>						
27.	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, өмчилсөн иргэдийн кадастрын зурагт өөрчлөлт оруулах асуудлаар шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийн хурлаар тухай бүрт нь хэлэлцэж шийдвэрлэх;	ДГЗБА	I-IV улиралд	"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах.		
28.	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хамтран өмчилсэн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлж, иргэний нэг удаа үнэгүй өмчлөх эрхийг нээж өгөх ажлыг зохион байгуулах;	ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 101, 181 дүгээр тогтоол, Дүүргийн Засаг даргын 2020-2024 он хүртэлх үндсэн чиглэл.		
29.	Өмчилсэн газартай холбоотой зөрчил маргааныг шүүх, хууль хяналтын байгууллага хянан шийдвэрлэхэд, шүүхэд тайлбар, нотлох баримтыг гаргаж хүргүүлэх, шүүх хуралд оролцох;	ДГЗБА	I-IV улиралд	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, "Иргэний хууль"-ийн 106.3 дах, заалтын хэрэгжилтийг хангах.		
30.	Нийслэлийн Засаг даргын газар өмчлүүлсэн	ДГЗБА	I-IV	"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн		

	захирамжийн дагуу тухайн иргэнд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт, кадастрын зураг, захирамжийн хуулбарыг хүлээлгэн өгөх.		улиралд	17.1, 17.2, 17.3 дах, заалт, ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/156 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах.
<b>Тав.Г Газрын кадастрын чиглэлээр хийгдэх ажил</b>				
31.	Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах, шар усны үерт өртөж болзошгүй нэгж талбарыг чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Барилга, хот байгуулалтын сайд (хуучнаар)-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 2023/02 дугаартай албан даалгавар.
32.	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фэтомониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах, тайланг хүргүүлэх;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 23.2.10 "Газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих," 23.2.21 "Газрын төлөв, байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, чанарын өөрчлөлтийг улсын хэмжээнд хянан дүгнэх үүрэг бүхий хяналт шинжилгээ (мониторинг)-ний сүлжээ ажиллуулах".
33.	Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг барьцаанд бүртгэх, чөлөөлөх бүртгэлийг хөтлөх, газар эзэмших, ашиглах эрхийг түдгэлзүүлэх сэргээх, бүртгэлийг газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, холбогдох албан бичигт хариу хүргүүлэх зэрэг газрын эрхтэй холбоотой лавлагааг эрх бүхий байгууллагуудад гаргаж өгөх;	ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журам, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргын 2019 оны А/45 дугаар "Газрын кадастрын мэдээллийн санг хөтлөх, хяналт тавих журам", Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын даргын 2016 оны А/188 дугаар "Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах журам".
34.	Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд хаяг солих, барилга байшин шинээр бүртгэж, баталгаажуулах, өмчилсөн газрын кадастрын зургийн нэр солих, өмчилсөн нэгж талбар нэгтгэх, хуваах өөрчлөлтийг хийх, иргэн, хуулийн этгээдэд кадастрын зурган мэдээллээр үйлчлэх;	ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журам, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргын 2019 оны А/45 дугаар "Газрын кадастрын мэдээллийн санг хөтлөх, хяналт тавих журам".
35.	Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын бүртгэл, нэмэлт өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг хөтлөх, хяналт тавих, тайлан гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.	ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 26.7. "Газрын кадастрын үр дүнг үндэслэн газрын нэгдмэл сангийн тайланг гаргана." дахь заалт; Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол
<b>Зургаа.Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил</b>				
36.	Дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулах;	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх.

37.	Газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшн (e-gazaf), албаны раше хуудас, утас-70003157, 77771285, масс мессеж (131413) зэрэг үйлчилгээнд хөгжүүлэлт хийж, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллах.	ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол.
38.	Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшнд хөгжүүлэлт хийж газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хувь хүн, хуулийн этгээдүүд өөрийн газартай холбоотой төрийн үйлчилгээг газрын удирдлагын нэгдсэн цахим системийг ашиглаж хүсэлт гаргах, хамааралтай мэдээ мэдээллийг зохих журмын дагуу түр-эн шуурхай авах боломжийг бүрдүүлэх.	ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол.
<b>Долоо. Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийгдэх ажил</b>				
39.	Газрын үнэлгээний зэрэглэл (бус)-ийн газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэглэх зааг, хязгаарыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах.	ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд.
40.	Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах.	ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд.
41.	Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/39 дугаар тогтоол шинэчлэгдсэн тохиолдолд газрын үнэлгээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх, дүгнэх, хэрэгжилтийг зохион байгуулах.	ДГЗБА	I-IV улиралд	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд.



2.4.Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд

Д/Д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ (га)	Төлөвлөлтийн нэгж талбар	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Сонгинохайрхан 21 дүгээр хороо	361 гарам	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
2.	Сонгинохайрхан 21 дүгээр хороо	361 гарам	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
3.	Сонгинохайрхан 21 дүгээр хороо	Рашаант	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
4.	Сонгинохайрхан 24 дүгээр хороо	Зээл	Зогсоолын талбай	364		15	ДГЗБА, ДЗДТГ 9092164-а, СБ721990
5.	Сонгинохайрхан 32 дугаар хороо	Хурган	Тоглоомын талбай	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
6.	Сонги-охайрхан 32 дугаар хороо	Эмээлт	Тоглоомын талбай	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
7.	Сонги-охайрхан 32 дугаар хороо	Хүй долоо	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
8.	Сонги-охайрхан 32 дугаар хороо	Бичигт	Тоглоомын талбай	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
9.	Сонги-охайрхан 32 дугаар хороо	Бичигт	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
10.	Сонги-охайрхан 32 дугаар хороо	Мал бордох	Төрийн захиргааны байгууллага	0.2		15	ДГЗБА, ДЗДТГ
11.	Сонги-охайрхан 33 дугаар хороо	Тахилт	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
12.	Сонгинохайрхан 33 дугаар хороо	Тахилт	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
13.	Сонгинохайрхан 33 дугаар хороо	Тахилт	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
14.	Сонгинохайрхан 33 дугаар хороо	Тахилт	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
15.	Сонгинохайрхан 33 дугаар хороо	Тахилт	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
16.	Сонгинохайрхан 33 дугаар хороо	Тахилт	Ус түгээх цэг	0.02		15	ДГЗБА, ДЗДТГ
17.	Сонгинохайрхан 33 дугаар хороо	Тахилт	Төрийн захиргааны байгууллага	0.15		15	ДГЗБА, ДЗДТГ

18.	Сонгинохайрхан 40 дүгээр хороо	Намаг гудамж	Цэцэрлэгт хүрээлэн	21.5	15	ДГЗБА, ДЗДТГ
<b>Нийт</b>						
			<b>385.98</b>			

**ГУРАВ.НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ**

Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбарын тоо	Чөлөөлөх газрын хэмжээ (га)	Зориулалт	Төлөвлөлтийн нэгж талбар	Хугацаа	Хариуцах байгууллага
<b>3.1.Нөхөх олговортойгоор чөлөөлөх газрын байршил, хэмжээ</b>								
1	2	Орбит гудамж	14	0.98	Үерт өртсөн		I-IV улиралд	ДЗДТГ, 2-р хороо
2	2	Толгойтын замаас хорооны цогцолбор хүртэлх авто зам	9	0.54	Авто замын трасс		I-IV улиралд	ДЗДТГ, 2-р хороо
3	4	Гэр хорооллыг орон сууцжуулах	935	63	Дахин төлөвлөлт		II-IV улиралд	ДЗДТГ, 4-р хороо
4	6	Хорооны цогцолборын урд	1	130	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 6-р хороо
5	9	Ерөнхий боловсролын 76-р сургуулийн урд талд	7	0.3	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 9-р хороо
6	9	163-р цэцэрлэгийн хойд талд	7	0.22	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 9-р хороо
7	10	Зүүнбаян уулын 14-26, 27 тоот	2	0.09	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 10-р хороо
8	10	Зүүнбаян уулын 13-28, 30 тоот	2	0.11	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 10-р хороо
9	10	Зүүнбаян-Уулын 12-28 тоот	1	0.06	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 10-р хороо
10	11	Хонхор 2-р гудамж	2	0.14	Авто зогсоол		I-IV улиралд	ДЗДТГ, 11-р хороо
11	20	Хангамж	16	0.46	Цэцэрлэг		II-IV улиралд	ДЗДТГ, 20-р хороо
12	23	Хангайн 40 дүгээр гудамж	4	0.21	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 23-р хороо
13	23	Чулуут 1- 8 тоот	1	0.05	Нийтийн эзэмшил		II-IV улиралд	ДЗДТГ, 23-р хороо

14	23	Хангайн 14 дүгээр гудамж	4	0.34	Цэцэрлэгт хүрээлэн		II-IV улиралд	ДЗДТГ, 23-р хороо
15	23	Хангайн 35 дугаар гудамж	2	0.07	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 23-р хороо
16	25	333-р цэцэрлэгийн зүүн талд	3	0.18	Хүүхдийн тоглоомын талбай, зогсоол		I-IV улиралд	ДЗДТГ, 25-р хороо
17	31	176-р цэцэрлэг	2	0.12	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 31-р хороо
18	32	Хурган	1	0.07	Автозамын далайд өртсөн орц гарц гаргах		I-IV улиралд	ДЗДТГ, 32-р хороо
19	33	Тахилт 27-р гудамж	2	0.12	Нарийн гудамж		I-IV улиралд	ДЗДТГ, 33-р хороо
20	33	271-р цэцэрлэгийн ард	4	0.18	Авто зогсоол		I-IV улиралд	ДЗДТГ, 33-р хороо
21	33	Хонгор дэлгүүрийн гудамж	2	0.11	Нарийн гудамж		I-IV улиралд	ДЗДТГ, 33-р хороо
22	33	Тахилт-2	2	0.17	Мухар гудамж		I-IV улиралд	ДЗДТГ, 33-р хороо
23	36	263-р цэцэрлэгээс Алтан-Овоо 780-р гудамж хүртэл	5	0.02	Авто зам, гүүр		II-IV улиралд	ДЗДТГ, 36-р хороо
24	36	Алтан-Овоо гудамж	4	0.28	Автобусны эцсийн буудлыг зогсоол		I-IV улиралд	ДЗДТГ, 36-р хороо
25	39	Хангайн 61 дүгээр гудамж	3	0.16	Цэцэрлэг		II-IV улиралд	ДЗДТГ, 39-р хороо
26	40	Баяншоуу 32-р гудамж 67 тоотос 168-р сургууль хүртэл	22	0.42	Авто зам		II-IV улиралд	ДЗДТГ, 40-р хороо
27	41	Хорооны баруун талаас Нийслэлийн 158-р цэцэрлэг рүү өгсөх зам	4	0.51	Авто зам, зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 41-р хороо
28	41	Нийслэлийн 158-р цэцэрлэгийн зогсоол	3	0.2	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 41-р хороо
29	41	Нийслэлийн 124-р сургуулийн гадна авто зогсоол	2	0.075	Авто зогсоол		II-IV улиралд	ДЗДТГ, 41-р хороо


30	41	Зээлийн 4-н төв зам Гэрэлт дэлгүүрээр баруун өгсөх	1	0.02	Авто зам	II-IV улиралд	ДЗДТГ, 41-р хороо
31	41	Big дэлгүүрийн эсрэг төв замаас НЕБ 168-р сургууль хүртэлх авто зам	2	0.02	Авто зам	II-IV улиралд	ДЗДТГ, 41-р хороо
32	43	Шинэ хорооны урд талд	3	0.15	Цэцэрлэгт хүрээлэн	I-IV улиралд	ДЗДТГ, 43-р хороо
33	43	252-р цэцэрлэг рүү явах авто зам	4	0.28	Авто замын трасс	I-IV улиралд	ДЗДТГ, 43-р хороо
<b>Нийт</b>			<b>1046</b>	<b>197,5</b>			

**ДӨРӨВ.ЗӨРЧИЛ АРИЛГАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ**

**4.1.Зөрчилтэй байршиллийн судалгаа**

Д/Д	Хороо	Газрын байршил	Чөлөөлөх объектын тоо	Объектын төрөл	Зөрчлийн хэлбэр	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1.	14	Ану төвийн барилгын баруун талын залгаа гараш	20 м.кв	Тоосго	Нийтийн зээмшлийн зам талбай чөлөөлөх	I-IV улиралд	ДГЗБА
2.	24	Баянхайрханы 77 дугаар гудамж	53 метр	Бетонн хашаа	Илүү талбайн зөрчил	I-IV улиралд	ДГЗБА
3.	24	Баруун салаа Бумбатын ам	6 метр	Төмөр хашаа	Орц, гарц гаргах	I-IV улиралд	ДГЗБА
4.	20	Бааз-1 гудамж	1	Төмөр хашаа	Илүү талбайн зөрчил	II-III улиралд	ДГЗБА
5.	22	22 дугаар хороо Хилчин 45 дугаар гудамжны 21а	1	Өргөтгөл	Зөвшөөрөлгүй	I-IV улиралд	ДГЗБА
6.	26	Мандал овоо 18 гудамж	1	Модон хашаа	Илүү талбайн зөрчил	II-III улиралд	ДГЗБА
7.	26	Мандал овоо 18 гудамж	1	Модон хашаа	Илүү талбайн зөрчил	II-III улиралд	ДГЗБА
8.	26	Мандал овоо 18 гудамж	1	Бетонн хашаа	Илүү талбайн зөрчил	II-III улиралд	ДГЗБА
9.	26	Мандал овоо 18 гудамж	1	Бетонн хашаа	Илүү талбайн зөрчил	II-III улиралд	ДГЗБА
10.	29	226 байрны автомат хаалт	1	Автомат хаалт	Зөвшөөрөлгүй	I-IV улиралд	ДГЗБА
11.	33	Баян-Уулын 3 дугаар гудамж	1	Модон хашаа	Зөвшөөрөлгүй	I-IV улиралд	ДГЗБА
12.	34	Баянголын ам	1	Модон хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	II-III улиралд	ДГЗБА
13.	34	Баянголын ам	1	Төмөр хашаа	Мухар гудамж	II-III улиралд	ДГЗБА
14.	35	Орбит 83 гудамж	1	Модон хашаа	Мухар гудамж	II-III улиралд	ДГЗБА
<b>Нийт</b>			<b>14</b>				

**5. ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

5. Газрын төлбөрийн орлого бүрдүүлэх чиглэлээр							
№	Дүүрэг	Зориулалт (нэгж талбар бүрийг зориулалтаар нь ангилна)	Газрын хэмжээ (га)	1м <sup>2</sup> газарт ногдуулах төлбөрийн хэмжээ (төг)	Татвар тооцох хугацаа нийт төвлөрүүлэх төлбөрийн хэмжээ (мян.төг)	Хариуцах байгууллага	
1		Гэр бүлийн хамтын хэрэгцээ	5455.2849	33	1,095,877.5	 <p>Хариуцах байгууллага</p> <p>Ут: 33101099 Факс: 64-65120699</p>	
2		Төсөвт байгууллага	738.84	72	394,556.6		
3		Нийтийн зориулалттай орон сууц	235.6123	268	512,231.6		
4		Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	2503.7832	581	8,044,030.9		
5		Нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц	186.5203	736	1,182,886.2		
6		Бүх төрлийн авто зогсоол (газар дээрх, доорх)	11.4249	400	4,323.2		
7		Нийтийн эдэлбэрийн газар	132.1954	69	105,546.9		
8		Инженерийн шугам сүлжээ түүний дэд бүтэц байгууламж	171.7077	82	176,191.6		
9	<b>Сонгинохайрхан</b>	Төмөр зам, нисэх онгоцны буудлын барилга байгууламж	5.6821	65	10,144.8		НТГ, Дүүргийн татварын хэлтэс
10		Төмөр зам, нисэх онгоцны буудлын хамгаалалтын бүс	1.7581	17	4,041.4		
11		Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	0.0424	280	44.1		
12		Шашин, сүм, хийд	4.1916	286	16,723.4		
13		Бүх төрлийн үйлдвэрлэл /хөдөө аж ахуйгаас бусад/	1097.4159	102	2,785,975.7		
14		Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	2614.1419	48	405,310.1		
15		Уурхайн эдэлбэрийн үйлдвэрлэлийн газар	95.0278	192	374,651.5		
16		Уурхайн эдэлбэрт олборлолт хийж буй газар	0	-	-		
17		Хөдөө аж ахуйн газар (балчээр, хадлан, тариалан)	4113.9636	0.12	15,982.0		
<b>Нийт</b>			<b>17367.5921</b>	<b>3231.12</b>	<b>15,175,517.4</b>		